

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Ц.Эрдэнээ.

ХХЕГ-ын ХЦ-ийн хил судлалын
хүрээлэн, хил судлалын
ухааны доктор, хурандаа

Хураангуй: Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудын нэгдмэл бодлого, цогц үйл ажиллагаагаар хангагддаг.

Түлхүүр үгс: Хилийн аюулгүй байдал, эрх зүйн тогтолцоо, үзэл баримтлал, номлол, дүн шинжилгээ, тэргүүлэх чиглэл.

Нэг. Хилийн аюулгүй байдлын үйл ажиллагааны эрх зүйн орчин

Дэлхий дахинд цэрэг, улс төрийн байдал хурцдаж, ОХУ-Украйн, Израил- Палестины дайн болон, шинжлэх ухаан, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, дэлхийн улсуудын харилцан хамаарал, эдийн засгийн хамтын ажиллагаа гүнзгийрч байгаа ч олон улсын байдал тогтворгүй, урьдчилан тааварлашгүй болж, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч, улс орнууд нэг нь нөгөөгөөсөө харилцан хамааралтай болж, буурай эмзэг эдийн засагтай улсуудад илэрхий мэдэгдэж байна.

Хөрш орнуудын улс төр, нийгэм эдийн засаг, хилийн бүс нутгийн хөгжил, хүн амын суурьшил, хил орчмын оршин суугч иргэдийн амьдралын хэв шинж, амьжиргааны түвшин зэрэг субъектив хүчин зүйлээс гадна хилийн хэсгийн байгаль, цаг уур, физик, газар зүйн онцлог зэрэг обктив хүчин зүйлүүд нь улсын хилийн нөхцөл байдалд шууд нөлөөлж байна. Мөн Монгол орны нийгэм, цаг үеийн болон хүн амын өсөлт бууралт, эдийн засгийн хямрал, орон нутаг дахь ажлын байрны хомсдол зэрэг нь хилийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэх хүчин зүйл болж байна.

Хилийн аюулгүй байдал гэдэг нь “Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ.” гэж Хилийн тухай хуульд тодорхойлсон. Энэ баталгаатай хангагдсан нөхцөл нь улсын хилийн баталгаажилт ба улсын хилийн найдвартай хамгаалалтаар хангагдаж байх учиртай.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдахаас өмнөх үеийн хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчин ямар байсныг авч үзэх зайлшгүй шаардлагатай юм. Монгол Улсын хилийн эрх зүйн харилцаа 1970 оныг хүртэл НАХЯ, ХЦУГ-ын тусгай дүрэм, заавраар зохицуулагдаж байсан байна.

Улсын хил, хилийн харилцаа, хил хамгаалах байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт, хилийн асуудлыг тусгайлан

хуулиар зохицуулах бодит шаардлага зэргийг харгалзан БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1973 оны 07-р сарын 16-ны өдрийн 161-р зарлигаар анхны “БНМАУ-ын Хил хамгаалах хууль”-ийг батлан мөрдүүлсэн бөгөөд энэ хуулиар улсын хилийн талаарх бодлого нь улсын хилийн хамгаалалт, ялангуяа Монгол-Хятадын хилийн хамгаалалтыг бүхэлд нь сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал байжээ. Хойд хилийн асуудлыг ЗХУ-тай ах дүүгийн, найрамдалт харилцаатай байсан гэдэг утгаар төдийлөн ач холбогдол өгдөггүй байсан байна.

БНМАУ-ын Хил хамгаалах хууль нь Монгол Улсын хилийн харилцаатай холбоотой бүхий л асуудлыг зохицуулах эрх зүйн шинэ орчин бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой юм. Манай улс социалист тогтолцооны үед НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болохын хувьд олон улсын гэрээ, конвенцод, тэр тусмаа хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой гэрээ, конвенцод нэгдэн орсон байдаг ч жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх талаар сул анхаарч ирсэн байдаг.

Гэвч 1958, 1976 оны БНМАУ, ЗСБНХУ-ын Хилийн гэрээ, 1962, 1988 оны БНМАУ, БНХАУ-ын хилийн гэрээ зэрэг баримт бичгүүд 1992 оны Үндсэн хуулийн өмнө бүрэн утгаараа хэрэгжиж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

БНМАУ-ын Хил хамгаалах хууль нь Монгол Улсын хилийн харилцаатай холбоотой бүхий л асуудлыг зохицуулах эрх зүйн шинэ орчин бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой юм. Манай улс социалист тогтолцооны үед НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болохын хувьд олон улсын гэрээ, конвенцод, тэр тусмаа хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой гэрээ, конвенцод нэгдэн орсон байдаг ч жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх талаар сул анхаарч ирсэн байдаг.

Гэвч 1958, 1976 оны БНМАУ, ЗСБНХУ-ын Хилийн гэрээ, 1962, 1988 оны БНМАУ, БНХАУ-ын хилийн гэрээ зэрэг баримт бичгүүд 1992 оны Үндсэн хуулийн өмнө бүрэн утгаараа хэрэгжиж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Нутаг дэвсгэрийн дээд эрх бол тухайн улс гүрний онцгой чухал эрх, тусгаар тогтнолын баталгаа юм.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж тогтоосон шугамыг Монгол Улсын хил (цаашид “Улсын хил” гэх) гэнэ” гэж тодорхойлжээ.

Улсын хил нь тухайн нутаг дэвсгэрийн дээд эрхийн хязгаарыг түүний мэдэлд орших байгалийн бүх баялгийн хамт зааглан тогтоодог учраас асар их нийгэм, улс төрийн ач холбогдолтой ойлголт юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын хилийг хуулиар бататгана” гэж заасан. Үндсэн хуулийн эдгээр тулгуур хэм хэмжээг хэрэгжүүлэх, хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдүүлэх үүднээс Монгол Улсын Их хурлын 2002

оны 20-р тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” хэмээх тулгуур баримт бичиг батлагдсан.

Монгол Улсын Их хурлын 2010 оны 48-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлын бүрэлдэхүүнд хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдлыг цогц байдлаар хамааруулсан нь хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход баримтлах төрийн бодлого юм.

Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан Олон улсын гэрээ, конвенцод нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс юм. Тухайлбал, олон улсын тулгуур баримт бичиг болох НҮБ-ын дүрмийн “Зорилго, зарчим” хэмээх 1-р бүлгийн 4-д «НҮБ-ын бүх гишүүн нь олон улсын харилцаандаа аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал буюу улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр сүрдүүлэх болон хүч хэрэглэх, түүнчлэн НҮБ-ын зорилгод харшлах ямарваа үйлдэл хийхийг хориглоно» гэж гишүүн орны хилийн халдашгүй дархан байдлыг баталгаажуулжээ.

Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх худалдааны тухай конвенц”-ийн (Манай улс 1986 оны 05-р сарын 11-нд нэгдэн орсон) 11-р зүйлд а) “энэхүү конвенц нь хэлэлцэн тохирогч аливаа улсад ёс суртахуун, эрүүл мэнд, аюулгүй байдлын үүднээс эсхүл хортон шавж, ургамал болон амьтны гаралтай өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор өөрийн газар нутагтаа хувь хүнийг нэвтрүүлэх, бараа оруулахыг хориглосон тохиолдолд дамжин өнгөрүүлэх үүрэг хүлээхгүй гэж заасан нь хилийн аюулгүй аюулгүй байдлын эрх зүйн орчинд шууд хамаарч байна.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлын баталгаажилт

Монгол Улсын Үндсэн хуулийн дөрөвдүгээр зүйлийн 1, 2-т:

–“Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”

–“Монгол Улсын хилийг хуулиар бататгана”

Монгол, Оросын хил:

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хилийг хоёр улсын хооронд **1958, 1976** онд байгуулсан хилийн гэрээний дагуу газар дээр нь тогтоон тэмдэглэж, хилийн дэглэмийн гэрээг 2006 онд шинэчлэн батламжилсан.

Монгол, Хятадын хил:

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн гэрээг **1962** онд байгуулж, хилийн дэглэмийн гэрээг **1988, 2010** онд шинэчлэн батламжилсан.

Монгол, Хятадын улсын хилийг **1975** онд Нэгдсэн Үндэсний Байгууллагад бүртгүүлсэн.

Монгол улсын хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчин

-Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц

-Монгол Улсын Үндсэн хууль

-Монгол Улсын Хилийн тухай хууль

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
- Батлан хамгаалах тухай хууль
- Дайны байдлын тухай хууль
- Гамшгийн тухай хууль
- Онц байдлын тухай хууль
- Эрүүгийн хууль
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээ 8, хэлэлцээр 26, санамж бичиг 5, протокол 11, бодлогын баримт бичиг 2 нийт 52 эрх зүйн баримт бичгийг хил залгаа улсын талтай хамтран хэрэгжүүлдэг.

Хоёр. Хил залгаа улсын хилийн аюулгүй байдал

Дэлхий нийтийн улс, төр болон геополитикт томоохон өөрчлөлтүүд гарч, олон туйлт систем, олон улсын аюулгүй байдалд шинэ дэг журам бий болгож байна.

Цэргийн номлолд гарсан өөрчлөлт нь “ирээдүйн дайны шинж чанар нь технологижсон, мэдээлэлжсэн нөхцөлд хязгаарлагдмал орон зайд буюу хил дагуух зах хүрээ бүс нутагт богино хугацаанд “түргэн” бөгөөд “ширүүн” дайн өрнөх магадлалтай” тул шинэ технологи, инновацыг дэмжих, мэдээллийн ажиллагааны чадавх, дайны бус цэргийн ажиллагааг дэмжихэд батлан хамгаалах бодлого, цэргийн стратегийг чиглүүлж байна.

ОХУ аюулгүй байдлын стратегиа зургаан жил тутам өөрчилдөг. Тус улс 2021 оны 7 дугаар сард Үндэсний аюулгүй байдлын стратегиа шинэчилсэн. Энэхүү баримт бичигт 2015 оны стратегиа зарчмын ялгаатай хэд хэдэн өөрчлөлт оруулжээ. Тухайлбал, баримт бичгийн 87 дугаар зүйлд АНУ, түүний холбоотон болон үндэстэн дамнасан корпорац, гадаадын засгийн газрын бус, худалдааны бус, шашны, экстремист, террорист байгууллагын зүгээс Оросын оюун санаа, ёс суртахуун, үзэл баримтлал, түүхт уламжлал, соёлын үнэт зүйлс рүү идэвхтэй халдах боллоо хэмээн тусгаж, АНУ болон түүний холбоотнууд ОХУ эсрэг үйл ажиллагаа явуулж байна гэсэн санааг шууд илэрхийлсэн байдаг. Үүнээс гадна АНУ зэвсгээр хөөцөлдөх үзэгдлийг ихээхэн дэвэргэж байна гэсэн шүүмжлэлтэй байр суурийг мөн хөндсөн байдаг. Түүнчлэн Украины үндсэрхэг үзэлтнүүд болон Орос хэл тээгч Украин иргэдийг зөрчил ширүүссэн, АНУ, ЕХ, НАТО Оросыг буруушаах үзэгдэл газар авсан зэрэг нь 2020 он хүртэл төлөвлөсөн Үндэсний аюулгүй байдлын стратегийг хугацаагүй болгох, зарим агуулгын өөрчлөлт хийхэд хүргэж, улмаар 2021 онд стратегийг шинэчлэх үндэслэл болсон гэж үзэж байна.

ОХУ-ын Үндсэн хуульд 2020 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 79 дүгээр зүйл бүхэлдээ аюулгүй байдлын асуудлыг хөндөж, улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг үл зөвшөөрөх зарчмыг баталгаажуулж, хэд хэдэн шинэ нэршил, ойлголтыг тусгажээ.

Үүнд:

Дотоодын хууль, тогтоомжийг олон улсын эрх зүйн хэм, хэмжээнээс илүүд үзэх;

Нутаг дэвсгэрийн нэгдмэл байдал;

Оросын төрт улсын түүхэн нэгдмэл байдлын үзэл санаа;

Түүхэн үнэн, эх орноо батлан хамгаалахад байгуулсан ард түмний гавьяаны үнэ цэнийг бууруулахыг үл зөвшөөрөх;

Орос хэлийг дэмжих, хамгаалах үйлсийн хүрээнд төрт улс байгуулах ард түмний ач холбогдол, үнэ цэн;

“Бурханд итгэх сүсэг, бишрэлийг” өвлөн үлдээсэн өвөг дээдсийн оюуны уламжлалт өв соёл зэрэг болно.

Эдгээр эрх зүйн суурь өөрчлөлт ОХУ Украинд явуулж буй “цэргийн тусгай ажиллагаа”-г дотооддоо эрх зүйн хувьд зөрчилгүй байлгах, үндэсний эрх ашигтай нийцүүлэх үндэслэл болж байна.

ОХУ-ын хилийн бодлогын үндсэн чиглэл:

1. ОХУ-ын улсын хилийн олон улсын болон эрх зүйн бүрдүүлэлтийг боловсронгуй болгох;

2. Хилийн аюулгүй байдлыг хангах;

3. Улс хоорондын хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

4. ТУХН-ийн гишүүн орнуудын гадаад хил дээр үндэсний болон хамтын аюулгүй байдлыг хангах;

5. ОХУ-ын хил орчмын бүс нутгийн нийгэм-эдийн засгийн болон оюун санааны үйл ажиллагааны үндсийг хөгжүүлэх;

6. Хилийн бодлогын салбарт шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо бий болгож, хөгжүүлэх хэмээн тодорхойлсон.

Хилийн бодлогын үндсэн зорилт нь:

1. ОХУ-ын бие даасан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

2. Улсын хилийн олон улсын болон эрх зүйн бүрдүүлэлтийг боловсронгуй болгох;

3. ОХУ-ын хилийн орон зайд цэргийн аюул, хямрал, мөргөлдөөнөөс сэргийлэх асуудлаарх улс хоорондын хамтын ажиллагаа;

4. ОХУ-ын нутаг дэвсгэр дээр бүх улсын зүгээс эдийн засгийн болон хүн ам зүйн түрэмгийлэл үйлдэхтэй тэмцэх;

5. ОХУ-ыг хилийн орон зай дахь үндэсний ашиг сонирхлоос нь болж зарим улс орнууд болон цэрэг-улс төрийн эвслийн зүгээс олон улсад ганцаардуулах гэсэн оролдлогыг таслан зогсоох;

6. Олон улсын гэрээнд үндэслэн ТУХН-ийн гишүүн орнуудын гадаад хил дээр ОХУ-ын ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангах явдал юм.

БНХАУ-ын хил хамгаалалтад гарч буй өөрчлөлт шинэчлэлийн талаар

БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2015 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Бээжинд болсон Чөлөөлөх дайны ялалтын 70 жилийн ойн цэргийн ёслолын жагсаалын үеэр, “... БНХАУ цэргийн тоогоо 300 мянгаар цөөрүүлнэ” хэмээн хэлснээр ХАЧА-ийн шинэчлэл эхэлсэн гэж үзэж болно. БНХАУ-ын Хятадын ардын чөлөөлөх арми (ХАЧА) нь 2018 оны 12 дугаар сард бүтцийн өөрчлөлт хийж цэргийн тойргоо Төв, Баруун, Хойд, Өмнөд, Умард гэх 5 тойрогт хуваан шинэчлэн зохион

байгуулж, хил хамгаалах хороодыг нэгтгэн бригад, батальоны тогтолцоонд шилжүүлэн хамгаалах зорилготой байсныг давших зориулалтад шилжүүлэн чадавхыг сайжруулахад анхааран ажиллаж байна.



Газар нутгийн маргаантай БНЭУ, Вьетнам зэрэг улстай хилийн хэлэлцээр хийж, асуудлыг намжаах бодлого баримталж байна.

- ❖ Шинжаан-Уйгарын өөртөө засах оронд “төмөр хэрэм” ажиллагааг зохион байгуулж, улс төрийн боловсрол олгох зорилгоор иргэдийг нийгэмшүүлэх, хятад хэл, соёлд сургахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг албадан хэрэгжүүлж байна.
- ❖ Улс төрийн бодлогыг эсэргүүцэгчид, хуулийн хариуцлагаас зайлсхийгсэд, гэмт этгээд (**7000-10000**)-үүд манай улстай хиллэдэг Монгол Алтайн нурууны өвөр хэсэгт нуугдан, орогнож байгаа талаар Хятадын тал мэдэгдсэн.
- ❖ Тус улсаас манай улстай хиллэдэг хэсэгт ашигт малтмал, газрын тосны олборлолтын үйл ажиллагааг улсын хилд ойртуулан явуулж, шинэ хот, суурин газрыг нутгийн гүндээ байгуулж эхэлсэн.
- ❖ Хилийн хэсэгт өндөр хүчдэлийн шугам татах, засмал зам тавих зэргээр дэд бүтцийг хурдацтай хөгжүүлж байна.

БНХАУ-ын үндэсний аюулгүй байдлын чиглэлээр баталсан хуулиуд

Хугацаа	Хуулийн нэр
2014.11.01	БНХАУ-ын Тагнуулын тухай хууль
	БНХАУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
2015.12.27	БНХАУ-ын Терроризмтой тэмцэх тухай хууль
2016.4.18	БНХАУ-ын Гадаадын ТББ-ыг зохицуулах тухай хууль
2016.11.7	БНХАУ-ын Кибер аюулгүй байдлын тухай хууль
2017.9.1	БНХАУ-ын Цөмийн аюулгүй байдлын тухай хууль
2020.6.30	БНХАУ-ын Хонконгийн засаг захиргааны онцгой бүсийн аюулгүй байдлын тухай хууль

Хилийн нөхцөл байдлын цаашдын чиг хандлага

Хөрш орнуудын улс төр, нийгэм эдийн засаг, хилийн бүс нутгийн хөгжил, хүн амын суурьшил, хил орчмын оршин суугч иргэдийн амьдралын хэв шинж, амьжиргааны түвшин зэрэг субьектив хүчин зүйлээс гадна хилийн хэсгийн байгаль, цаг уур, физик, газар зүйн онцлог зэрэг объектив хүчин зүйлүүд нь улсын хилийн нөхцөл байдалд шууд нөлөөлж байна.

Мөн нийгэм, цаг үеийн болон хүн амын өсөлт бууралт, эдийн засгийн хямрал, орон нутаг дахь ажлын байрны хомсдол зэрэг нь хилийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэх хүчин зүйл болж байна.

Оросын Холбооны Улсын цэргийн тусгай ажиллагаанд оролцсон **3000** гаруй иргэд гэрээгээ цуцалж, Бүгд Найрамдах Алтай, Тува Улсын нутаг дэвсгэрт тархан суурьшсан. Дээрх иргэдэд Оросын Холбооны Улсын Засгийн газраас хуулийн хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргасан тохиолдолд бөөн иргэд улсын хил зөрчиж болзошгүй нөхцөл байдал бий болсон.

-БНХАУ-ын коммунист намын бодлогыг эсэргүүцэгчид, Шинжаан Уйгарын салан тусгаарлах, хэт даврах үзэлтнүүд, Өвөр Монголын Өөртөө Засах орны иргэд хэл, соёлын дарамт шахалтаас зугтах зэргээр улсын хилийг бөөнөөр зөрчиж болзошгүй байна.

Гурав. Хилийн аюулгүй байдлын үйл ажиллагааны эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудал

Монгол Улс нь газар зүйн байрлалаараа хоёр их гүрний дунд, азийн геостратегийн чухал түшиц газар, их гүрнүүдийн геополитик, гео эдийн засаг, соёл иргэншлийн ашиг сонирхлын уулзвар, дэлхийн шашнуудын нөлөөллийн зах нийлсэн заагууд дээр оршдог.

Тэгэхээр хилийн аюулгүй байдлын гадаад орчинд хил залгаа улсуудын дайн мөргөлдөөн болон тэдгээрийн дотоодод үүссэн хямрал нь Монгол улсын үндэсний аюулгүй байдалтай шууд хамааралтай тул хүрээлэн буй геополитикийн орон зай, дотоод нөхцөл байдалд тохируулж, хил хамгаалалтын тактик, стратегийг боловсруулж, аюулгүй байдлын суурь ухагдахууныг эргэн харах шаардлага үүсэж байна.

Улсын хилийн аюулгүй байдал улсын хилийн халдашгүй дархан байдал, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээ, бусад улс орны туршлага, холбогдох хилийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааг судлан үзсэний үндсэн дээр Монгол Улс нь хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх нь зүйтэй байна.

Улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоог бие даасан хилийн албаны тухай бие даасан хуулиар зохицуулах.

Улсын хил хамгаалалтыг олон улсын жишигт нийцсэн, өөрийн улсын онцлогт тохирсон бүсчилсэн байдлаар зохион байгуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт хийх.

Монгол Улсын газар зүй, нийгэм, эдийн засгийн онцлог, улсын хил дээр гарч буй зөрчлийн хэлбэр, шалтгаан нөхцөлийг үндэслэн улсын хил хамгаалалтыг говь цөлийн, тал хээрийн, ой тайгын, уулын болон усан гэж бүсчлэн Бүс нутгийн удирдах газрыг байгуулан хил хамгаалалтыг зохион байгуулах зайлшгүй шаардлага бий болж байна.

Хил хамгаалах албанд бүтэц, зохион байгуулалтын дорвитой шинэчлэл хийж, хууль сахиулах, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зүй тогтлын дагуу дэлхийн улс орнуудын нийтлэг жишигт нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй байна.

Иймд хилийн аюулгүй байдлыг хангах, хөрш орнуудтай байгуулсан хилийн дэглэмийн гэрээг хүндэтгэн сахиулах, хилийн зөрчил, хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, зэргэлдээ улсын хил хамгаалах чиг үүрэг бүхий ижил түвшний байгууллагуудтай улсын хилийг хамтран хамгаалах тусгайлсан чиг үүрэг бүхий хилийн аюулгүй байдлын хүчнээр улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, тухайн байгууллагын тогтолцоо, чиг үүргийн талаарх зохицуулалтыг шинээр тусгах;

Хилийн тухай хуульд эрх зүйн болон хил хамгаалах практик үйл ажиллагаанаас урган гарсан бодит шаардлагыг иш үндэс болгон дор дурдсан эрх зүйн зохицуулалт шинээр хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Манай орны эдийн засагт уул уурхайн салбарын эзлэх хувь нэмэгдэхийн хирээр хилийн бүсэд ашигт малтмалын хайгуул, ашиглалттай холбоотой үйл ажиллагаа өргөжиж байгаа нь тухайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын эрх ашиг, улсын хилийн болон хил орчмын дэглэмийн эрх ашигтай зөрчилдөхөд хүргэж, улсын хил хамгаалалтын мөн чанарыг алдагдуулахад хүрч байна.

Иймд хил орчмын нутаг дэвсгэрт хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээг хэрэгжүүлэх, улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн зөрчил, хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн бүсийг 50 км-ээс илүүгүй байхаар тогтоож, тухайн бүсэд үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг хийх;

Хилийн тухай нэг хуульд хил хамгаалахтай холбоотой олон асуудлыг нэг бүрчлэн тусгах боломжгүй учраас хилийн тухай хуулиас гадна:

а) Хилийн албаны тухай хууль (хилийн албаны болон бүс нутгийн удирдах газрын бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрх, чиг үүрэг гэх мэт асуудлууд орно.);

б) Хилийн аюулгүй байдлын алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль (хуулийн зорилт, алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, алба хаагчийн үйл ажиллагааны зарчим, алба хаагчийн тангараг, алба хаагч, албан тушаалын ангилал, төрөл, алба хаагчийн үүрэг, эрх, хилийн аюулгүй байдлын хүчний үүрэг, алба хаагчид хориглох зүйл, эрхийн хязгаарлалт, алба хаагчийн дүрэмт хувцас, цол, цол олгох үндэслэл, хугацаа, цол хугацааны өмнө олгох, хойшлуулах, бууруулах, хураах, албан

тушаалд тавигдах шаардлага, албанд томилох, хүний нөөцийн жагсаалт гаргах, сонгон шалгаруулалт явуулах, өөр албанд шилжүүлэх, албаны бүрэн эрхийг түдгэлзүүлэх, алба хаагчийн үүрэг орлон гүйцэтгэх, түр болон бүр мөсөн чөлөөлөх, алба хаагчийн урамшил, шийтгэл оногдуулах, алба хаагчийн нийгэм, хууль зүй, эдийн засгийн баталгаа, тэтгэвэр, тэтгэмж гэх мэт асуудал орно.);

в) Хилийн боомтын тухай хууль (хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн нэр томьёо, хилийн боомтыг нээх, хаах, зэрэглэлийг өөрчлөх, улсын хилээр нэвтрүүлэх асуудал, улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт явуулах бусад байгууллагууд, тэдний чиг үүрэг, харилцан ажиллагаа, хилийн боомтод мөрдөх журам, хилийн боомтын бүс, хяналт, шалгалтын зурвас, хилийн боомтод нэвтрүүлэх зөвшөөрөл, хилийн боомтын зөвлөл, хилийн боомтын байгууламж, төхөөрөмжлөл, хүлээлгэх хариуцлага гэх мэт асуудлууд хуульчлагдах ёстой.)

г) Отрядын дүрэмд- а) хил хамгаалах отрядын бүтцийг ялгавартай тогтоох, б) хилийн застав дундын удирдлага, хяналт шалгалтыг ойртуулах, сургалт, жигдрэлтийг хангах, хилийн эрэл бие даан явуулах бэлтгэл хүч, хилийн тагнуул бүхий нэгжийг буй болгох, в) отряд цомхон, чадварлаг, маневрлах чадвартай бэлтгэл хүчинтэй байх, г) отрядын өдөр тутмын хамгаалалтыг гэрээт харуулаар гүйцэтгүүлэх, д) аж ахуйн ажил хийх орон тооны туслах ажилтантай болох зэрэг асуудлыг тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангахад юуны өмнө дараах стратегийг асуудалд анхаарвал зохистой гэж үзэж байна.

Нэгдүгээрт: улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангах эрх зүйн суурь баримт бичгүүдийг боловсронгуй болгох;

Хоёрдугаарт: улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангахад төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, үүргийн талаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

Гуравдугаарт: улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр дэх аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлийг тодорхойлох, шинжилгээ хийх, өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан аюулгүй байдалд нөлөөлөх байдлыг тогтоох;

Дөрөвдүгээрт: хилийн аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх чиглэлээр судалгаа хийх;

Тавдугаарт: улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр дэх аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлийг саармагжуулах зорилгоор Хил хамгаалах байгууллагаас одооноос зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;

Зургаадугаарт: улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт шинээр үүсэж бий болж буй нөхцөл байдлыг харгалзан хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлийг тогтоох;

Долоодугаарт: улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангах үндсэн гол байгууллага болох Хил хамгаалах байгууллагын хүч хэрэгсэл, техник технологийн хангалт, түүний бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлжилтийн байдал нь өмнөө тавьсан зорилго зорилт, үүргээ стратеги, операц, тактикийн түвшинд биелүүлэх боломжтой эсэхийг судлах;

Наймдугаарт: улсын хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалах урлагийн онолыг хөгжүүлэх, боловсронгуй болгох.

Дүгнэлт

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчинд хил залгаа улсуудын хооронд болон тэдгээрийн дотоодод үүссэн хямрал, мөргөлдөөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд шууд хамааралтай тул хүрээлэн буй геополитикийн орон зай, дотоод нөхцөлд байдалд тохируулж, хил хамгаалалтын тактик, стратегийг боловсруулж, аюулгүй байдлын суурь ухагдахууныг эргэн харах шаардлага үүсэж байна. Хилийн аюулгүй байдлын талаар өнөөгийн мөрдөж буй эрх зүйн актууд, хуулиудад бүрэн хэмжээгээр тусгагдаагүй байгаа ба цаашид түүнийг улам боловсронгуй болгох шаардлага урган гарч байна.

Үүний тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “хилийн аюулгүй байдал”-ын талаар нэмэлт өөрчлөлт оруулах, тайлбар өгөх;

2. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод хилийн аюулгүй байдлыг хангах талаар нэмэлт, тодотгол оруулах;

3. Олон улсын харилцааг сайжруулахад түлхэц болох улс орны улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд нийцсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

4. Хөрш улстай хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын гэрээ, хэлэлцээрийг шинэчлэн боловсронгуй болгох;

Монгол Улсын эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиудад хилийн аюулгүй байдлыг хангах талаар тэр бүр бүрэн хэмжээгээр тусгаагүй учир тэдгээрт зохих хэмжээгээр нэмэлт оруулах шаардлагатай байна.